

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРОО**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг

| | |
|--|-------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 3 – 4 |

1. *“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

3 – 4

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 4 дүгээр сарын 10-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Т.Аубакир, Д.Батбаяр, Ж.Батсуурь, Х.Болормаа, Х.Булгантуяа, П.Ганзориг, П.Мөнхтулга, Б.Түвшин, Да.Цогтбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, мөн газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн дарга Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 10-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 00 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 55.2 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог нэрээр нь танилцуулна.

Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Ринчиндоржийн Батболд жагсаалт, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог, Жадамбаагийн Баясгалан жагсаалт, Гомбын Ганбаатар 7 дугаар тойрог, Цэрэнпилийн Даваасүрэн 4 дүгээр тойрог, Пүрэвжавын Сайнзориг 11 дүгээр тойрог, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан 1 дүгээр тойрог, Батжаргалын Заяабал 2 дугаар тойрог, Баатаржавын Мөнхсоёл жагсаалт, Загджавын Мэндсайхан 2 дугаар тойрог, Чинбатын Номин 11 дүгээр тойрог, Даваахүүгийн Пүрэвдаваа жагсаалт, Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4 дүгээр тойрог, Баттогтохын Чойжилсүрэн 2 дугаар тойрог, Дашцэрэнгийн Энхтүвшинд жагсаалт.

Эдгээр гишүүд хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга, Чойдоржийн Чимэгэрэл Гаалийн ерөнхий газрын барааны ангиллын хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг төсөлд нэмж тусган төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарыг Та бүхэнд тараасан.

Тогтоолын төслийн эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Тогтоолын төсөл төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулна.

Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Гишүүдэд баярлалаа.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 10 цаг 04 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД